



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 416

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 23.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 60 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Х.БУЛГАНТУЯА

Засгийн газрын 2023 оны 11 дүгээр
сарын 29-ний өдрийн 116 дугаар
тогтоолын хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛСНӨӨР ТООЦОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Даатгуулагчийн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 23 дугаар зүйлд заасан хугацааг нийгмийн даатгалын шимтгэл (цаашид “шимтгэл” гэх) төлсөн хугацаанд оруулан тооцоход энэ журмыг баримтална.

1.2. Даатгуулагчийн шимтгэл төлснөөр тооцох хугацааг энэ журмын 2 дахь хэсэгт дурдсан баримт бичигт үндэслэн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцно.

Хоёр.Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох хугацааг тодорхойлох

2.1. Ажилтны 1991 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хөдөлмөрийн гэрээгээр ажилласан хугацааг тодорхойлохдоо хөдөлмөрийн дэвтрийг, эсхүл ажилд орсон, ажлаас чөлөөлсөн тухай шийдвэрийн архивын лавлагааг, архивын баримтаар нотлогдохгүй тохиолдолд ажилласан жилийг сэргээн тогтоосон шүүхийн шийдвэрийг үндэслэнэ.

2.2. Ажилтны төр, хувийн өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага, хөдөө аж ахуйн нэгдэл, хоршоолол, шашны байгууллагад 1991 оны 07 дугаар сарын 01-ээс 1995 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл ажиллаж, цалин хөлсний сангаас нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлохдоо энэ журмын 2.1-д заасан баримт бичиг болон байгууллага нь цалингийн сангаас 13.5 хувиар тэтгэврийн санд шимтгэл төлсөн тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын архивын лавлагааг тус тус үндэслэнэ.

2.3. Иргэний 1995 оноос өмнө цэргийн жинхэнэ болон хугацаат цэргийн алба хаасан хугацааг тодорхойлохдоо цэргийн жинхэнэ алба хаасан хугацааг цэргийн байгууллагын архивын лавлагаа, хугацаат цэргийн алба хаасан хугацааг цэргийн батлах (үнэмлэх), эсхүл цэргийн байгууллагын архивын лавлагаа, алба хаасан хугацааг тогтоосон шүүхийн шийдвэрийг үндэслэнэ.

2.4. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10-аас доошгүй жил төлсөн, төрүүлсэн болон гурав хүртэл настайд нь үрчлэн авсан хүүхдээ зургаан нас хүртэл өсгөсөн эхийн төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэд бүрийн тоогоор нэг жил зургаан сараар тооцсон хугацааг хүүхдийн төрсний гэрчилгээ, эсхүл шүүхийн шийдвэр, эрх бүхий байгууллагын лавлагааг үндэслэн тодорхойлно.

2.5. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн цэргийн жинхэнэ алба хаасан нэг жилийг тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн нэг жил зургаан сараар тооцсон хугацааг цэргийн батлах (үнэмлэх), эсхүл цэргийн байгууллагын архивын лавлагаа, алба хаасан хугацааг тогтоосон шүүхийн шийдвэрийг үндэслэнэ.

2.6.1995 оноос өмнө ажилласан хугацааг холбогдох хуулийн дагуу нөхөн тооцож баталгаажуулсан хугацааг нийгмийн даатгалын байгууллагаас олгосон “Баталгаажилтын хуудас”, эсхүл лавлагааг үндэслэн тодорхойлно.

2.7.Даатгуулагчийн Дипломат албаны тухай хуулийн дагуу цаг уурын хүнд нөхцөл бүхий улсад ажилласан нэг жилийг нэг жил зургаан сараар тооцсон хугацааг тодорхойлохдоо гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас дипломат албан тушаалд томилсон тушаал, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолтыг үндэслэнэ.

Гурав.Бусад

3.1.Энэхүү журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----oOo----